



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн бүртгэлд
2024 оны 02 сарын 06-ны
өдрийн 6593 дугаарт бүртгэв.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2023 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 793

Улаанбаатар хот

“Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны”
зуучлагч (брокер)-ийн үйлчилгээний төлбөр,
хураамж”-ийг тогтоох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.10, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч (брокер)-ийн спот болон форвард гэрээний арилжаанаас авах үйлчилгээний төлбөр, хураамжийн дээд хязгаарыг худалдан авагч талаас 0.5 хувиас ихгүй, худалдагч талаас 1 багц тутамд 200,000 төгрөгөөс ихгүй байхаар тогтоосугай.

2. Энэ тогтоолын 1-д заасан төлбөр, хураамжийн дээд хязгаарыг холбогдох дүрэм, журамдаа тусгаж, мөрдөж ажиллахыг уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч (брокер)-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдүүдийн удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-д даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

1518C01795